



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/110

Сүхбаатар сум

### Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29 дүгээр зүйлийн 29.2, "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1- 6.6 , 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8, 12 дугаар зүйлийн 12.1, 22 дугаар зүйлийн 22.2, Засгийн газрын 2018 оны "Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчний жагсаалт батлах тухай" 225 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээ тогтоох тухай" 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн эрүүл мэнд, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт, халдварт, шимэгчлэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал, амьтны өвчлэлийн байдлыг бүртгэх мэдээлэх, ажил үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулах, хяналт тавих зорилгоор аймгийн хэмжээнд "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ"-г зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай. Үүнд:

2.1. Лабораторийн оношилгоо, шинжилгээ, дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтад эрсдэлтэй бүсийн мэдрэмтгий мал, амьтныг технологит хугацаанд бүрэн хамруулах

2.2. Эрсдэл бүхий нутгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэх, тууварлах, шаардлагагүй нөхцөлд голомт бүхий аймаг, сумдад зорчихгүй байх, хүн мал, амьтны шилжилт хөдөлгөөнд байнга хяналт тавьж ажиллах.

2.3. Дээрх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг сумдын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулан, чанартай шуурхай гүйцэтгэхэд удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах.

3. Био бэлдмэл болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих, орон нутагт нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/-т үүрэг болгосугай.

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx


430801356

4. Уг арга хэмжээний үр дүнг хянах сериомониторинг хийхэд шаардлагатай зардлыг аймгийн 2020 оны төсөвт батлагдсан мал эмнэлгийн үйлчилгээний зардлын дүнгийн 1 хувиар тооцож санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/ -д үүрэг болгосугай.

5. “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулах явцад хариуцлагагүй хандсан хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, хамтран ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/ нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч дарга /Ж.Сайнцог/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ШОРГИЛ